



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/120/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10-11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11-12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12-14
4. Аудитын тайлан	15-18
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15-16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16-17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17-18
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18-19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шитгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ШААМАР СУМЫН ДУЛААНХАН ТОСГОНЫ
3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ЭНХМАА ТАНАА**

2025.02.25 № СЭА-2025/120/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус цэцэрлэг нь сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 6,089.0 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан бөгөөд Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дугаар сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 18,122.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан

өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.1 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	88,266,463.58	83,424,942.28
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	67,637,889.29	68,930,292.10
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	67,637,889.29	68,930,292.10
3121	Төгрөг	67,637,889.29	68,930,292.10
31211	Төрийн сангийн харилцах	67,637,889.29	68,930,292.10
33	АВЛАГА	1,100,000.00	1,100,000.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,100,000.00	1,100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,528,574.29	13,394,650.18
354	Хангамжийн материал	19,528,574.29	13,394,650.18
3541	Бичиг хэргийн материал	2,184,605.16	2,038,441.50
3542	Аж ахуйн материал	15,537,444.43	9,290,894.68
3546	Хүнсний материал	598,069.70	856,859.00
3547	Бусад хангамжийн материал	1,208,455.00	1,208,455.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,521,087,164.34	1,206,468,820.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,521,087,164.34	1,206,468,820.48
392	Биет хөрөнгө	1,514,110,114.38	1,199,541,770.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,635,951,632.61	1,287,600,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-139,518,946.32	-100,146,666.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49,381,087.34	50,193,787.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32,137,515.70	-36,035,488.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,474,433.21	4,657,253.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,008,252.82	-4,405,669.48
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,411,450.00	1,731,450.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,926,504.94	-4,622,794.94
39217	Ном	1,482,731.00	569,900.00
393	Биет бус хөрөнгө	6,977,049.96	6,927,049.92
39301	Программ хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-299,950.04	-349,950.08
39303	Бусад биет бус хөрөнгө	7,027,000.00	7,027,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,609,353,627.92	1,289,893,762.76
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,117,620.12	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,117,620.12	
413	Өглөг	1,117,620.12	
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,117,620.12	
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,608,236,007.80	1,289,893,762.76
51	Засгийн газрын хувь оролцоо	1,608,236,007.80	1,289,893,762.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	92,623,427.80	92,623,427.80
51101	Өмч: - төрийн	92,623,427.80	92,623,427.80
512	Хуримтлагдсан үр дүн	1,179,400,142.96	1,093,960,469.47

5121	Өмнөх үеийн үр дүн	1,179,400,142.96	1,412,302,714.51
5122	Тайлант үеийн үр дүн		-318,342,245.04
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	336,212,437.04	103,309,865.49
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,609,353,627.92	1,289,893,762.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	768,209,500.00	1,070,585,329.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		4,835,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		4,835,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00
120009	Бусад орлого		4,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	768,209,500.00	1,065,750,329.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	692,694,100.00	995,849,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	692,694,100.00	995,849,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,515,400.00	69,900,629.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,515,400.00	69,900,629.34
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	774,310,675.13	1,100,999,004.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	774,310,675.13	1,100,999,004.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	774,310,675.13	1,089,219,704.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	513,087,749.59	785,729,938.87
210101	Үндсэн цалин	371,530,711.13	500,597,262.25
210102	Нэмэгдэл	124,219,681.25	241,553,726.62
210104	Урамшуулал	17,337,357.21	43,578,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,047,608.02	97,727,131.82
210201	Тэтгэврийн даатгал	44,033,444.52	67,811,008.74
210202	Тэтгэмжийн даатгал	5,225,264.14	7,980,523.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,101,071.35	3,937,461.72
210204	Ажилгүйдлийн даатгал	920,595.60	3,599,627.82
210205	Эрүүл мэндийн даатгал	9,767,232.41	14,398,510.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,163,020.12	68,009,879.22
210301	Гэрэл, цахилгаан	7,484,420.04	10,561,089.69
210302	Түлш, халаалт	65,378,600.08	57,398,789.53
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	50,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	390,000.00	945,463.66
210401	Бичиг хэрэг		146,163.66
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	390,000.00	

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		799,300.00
2105	Нормативт зардал	55,161,915.00	71,225,737.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		74,000.00
210502	Хоол, хүнс	55,161,915.00	71,151,737.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,565,110.00	2,406,500.00
210604	Урсгал засвар	2,565,110.00	2,406,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	850,100.00	2,059,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	850,100.00	2,059,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,045,172.40	61,115,853.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,267,621.00	22,080,679.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,541,350.00	6,002,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,236,201.40	33,032,473.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		11,779,299.90
2132	Бусад урсгал шилжүүлэг		11,779,299.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		11,779,299.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-6,101,175.13	-30,413,674.84
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		287,928,570.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		287,928,570.20
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-287,928,570.20
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-6,101,175.13	-318,342,245.04

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	768,209,500.00	1,070,585,329.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		4,835,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		4,835,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00
120009	Бусад орлого		4,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	768,209,500.00	1,065,750,329.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	692,694,100.00	995,849,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	692,694,100.00	995,849,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,515,400.00	69,900,629.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,515,400.00	69,900,629.34
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	729,272,922.61	1,062,950,226.53

21	УРСГАЛ ЗАРДАЛ	729,272,922.61	1,062,950,226.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	729,272,922.61	1,051,170,926.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	508,123,966.26	785,669,769.08
210101	Үндсэн цалин	356,546,544.06	488,423,722.95
210102	Нэмэгдэл	135,430,737.21	255,000,594.81
210104	Урамшуулал	16,146,684.99	42,245,451.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,640,711.35	97,786,179.11
210201	Тэтгэврийн даатгал	47,153,286.69	67,611,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,544,030.54	7,954,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,378,225.46	3,977,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,050,980.79	3,652,539.53
210205	Эрүүл мэндийн даатгал	10,514,187.87	14,590,939.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,045,400.00	67,430,629.34
210301	Гэрэл, цахилгаан	7,484,420.04	9,225,824.50
210302	Түлш, халаалт	64,260,979.96	57,704,804.84
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	55,904,405.00	71,411,649.00
210502	Хоол, хүнс	55,904,405.00	71,411,649.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	2,470,000.00
210604	Урсгал засвар	3,470,000.00	2,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,240,100.00	2,059,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,240,100.00	2,059,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,848,340.00	24,343,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,060,540.00	18,538,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,787,800.00	5,804,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		11,779,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		11,779,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		11,779,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	38,936,577.39	7,635,102.81
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		6,342,700.00
	Дотоод эх үүсвэрээр		6,342,700.00
223001	Бусад хөрөнгө		6,342,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-6,342,700.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	38,936,577.39	1,292,402.81
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		67,637,889.29

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	68,930,292.10
----	---	---------------

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,623,427.80	336,212,437.04	1,179,400,142.96	1,608,236,007.80
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			232,902,571.55	232,902,571.55
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-232,902,571.55		-232,902,571.55
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			-318,342,245.04	-318,342,245.04
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,623,427.80	103,309,865.49	1,093,960,469.47	1,289,893,762.76

1,148,050.6 1,069,292.9 78,757.7 93.1

2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,148,015,500.00	1,069,292,926.53	78,722,573.47	94.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,148,015,500.00	1,069,292,926.53	78,722,573.47	94.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,136,236,200.00	1,057,513,626.53	78,722,573.47	93.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	845,614,400.00	785,669,769.08	59,944,630.92	92.9
210101	Үндсэн цалин	536,502,100.00	488,423,722.95	48,078,377.05	91.0
210102	Нэмэгдэл	277,522,500.00	255,000,594.81	22,521,905.19	91.9
210104	Урамшуулал	31,589,800.00	42,245,451.32	-10,655,651.32	133.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,445,600.00	97,786,179.11	3,659,420.89	96.4
210201	Тэтгэврийн даатгал	68,984,100.00	67,611,300.00	1,372,800.00	98.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,114,500.00	7,954,200.00	160,300.00	98.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,057,800.00	3,977,200.00	80,600.00	98.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,057,800.00	3,652,539.53	405,260.47	90.0
210205	Эрүүл мэндийн даатгал	16,231,400.00	14,590,939.58	1,640,460.42	89.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,430,629.34	67,430,629.34	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	9,225,824.50	9,225,824.50	0.00	100.0
210302	Түлш, халаалт	67,532,175.50	57,704,804.84	9,827,370.66	100.0
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	500,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал			0.00	
2105	Нормативт зардал	75,062,300.00	71,411,649.00	3,650,651.00	95.1
210502	Хоол, хүнс	75,062,300.00	71,411,649.00	3,650,651.00	95.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,470,000.00	2,470,000.00	0.00	100.0

210604	Урсгал засвар	2,470,000.00	2,470,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал			0.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,059,200.00	2,059,200.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,059,200.00	2,059,200.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,326,700.00	30,686,200.00	1,640,500.00	94.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,522,000.00	24,881,500.00	1,640,500.00	93.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,804,700.00	5,804,700.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,779,300.00	11,779,300.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,779,300.00	11,779,300.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,779,300.00	11,779,300.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			0.00	
	Дотоод эх үүсвэрээр			0.00	
223001	Бусад хөрөнгө			0.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,148,050,589.29	1,070,585,329.34	77,465,259.95	
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,000,684,700.00	995,849,700.00	4,835,000.00	
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,000,684,700.00	995,849,700.00	4,835,000.00	
131009	Оны эхний үлдэгдлээс	67,637,889.29		67,637,889.29	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			0.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	79,728,000.00	69,900,629.34	9,827,370.66	
132001	Орон нутгийн төсвөөс	79,728,000.00	69,900,629.34	9,827,370.66	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		35,000.00	-35,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00	-35,000.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР		4,800,000.00	-4,800,000.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		67,637,889.29	-67,637,889.29	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		68,930,292.10	-68,930,292.10	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэг нь “ Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, хүүхдийн онцлогт нийцүүлэн сургалт үйл ажиллагааг чанар үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад дэвшүүлэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хамран сургах тойргийн 5 настай хүүхэд бүрийг СӨБ-д тэгш хамруулан сургуульд суралцах бэлтгэлийг хангах;

- Байгууллагын үйл ажиллагааны үр дүн, багшийн ажлын гүйцэтгэлд суурилан байгууллага болон багшийн хөгжлийг дэмжих, уян хатан, олон хэлбэрт сургалт үйл ажиллагааг хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил, байгууллага үйлчилгээний чанарт ахиц гаргах;
- Байгууллагын багш, ажилтан ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг эрхэмлэн баг хамт олноороо харилцааны эерэг хандлага, соёл төлөвшүүлэх;
- Хүүхдийг шим тэжээллэг хоол хүнс хэрэглэх, зохистой дадал хэвшилд сургах, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний чанарыг сайжруулах;
- Цэцэрлэгийн хамтран ажиллах чадавхыг бэхжүүлэх, цэцэрлэгийн менежментийг сайжруулахад мэргэжлийн холбоо, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт,

шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус цэцэрлэг нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 319,459.9 мянган төгрөгөөр буюу 24.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	67,637.9	68,930.3	1,292.4
Авлага	1,100.0	1,100.0	-
Бараа материал	19,528.6	13,394.7	(6,133.9)
Үндсэн хөрөнгө	1,521,087.2	1,206,468.8	(314,618.3)
Нийт хөрөнгө	1,609,353.6	1,289,893.8	(319,459.9)
Өр төлбөр			

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,608,236.0	1,289,893.8	(318,342.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,609,353.6	1,289,893.8	(319,459.9)

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 68,930.3 мянган төгрөг болж 1,292.4 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 13,394.7 мянган төгрөг болж 6,133.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 97,271.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, байгууллагын ӨХК-ын шийдвэрийг үндэслэн эрхлэгчийн 2024 оны 04 дүгээр А/11 дугаар тушаалаар цаашид ашиглах боломжгүй 6,392.7 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хасч, үйл ажиллагаанд 97,012.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,352,029.4 мянган төгрөг болж 361,948.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 6,342.7 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж худалдан авч, аймгийн ИТХ-ын 2024 оны 04 сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоолоор 348,351.6 мянган төгрөгийн өртөгтэй цэцэрлэгийн барилга, 19,940.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хассан нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 145,560.6 мянган төгрөг бөгөөд 1,206,468.8 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,171,410.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 73,652.1 мянган төгрөг, нийт 1,245,062.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, шимтгэлийн зардлыг 364,609.7 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 46,607.6 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн зардлыг 201.3 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 1,308.4 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 31,283.4 мянган төгрөгөөр нийт 444,010.4 мянган төгрөгөөр бууруулж, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,078.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 802,131.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 7 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 1,068,322.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 79,728.0 мянган төгрөгийн нийт 1,148,050.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 285,487.4 мянган төгрөгөөр, Тогтмол зардлыг 6,075.9 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 23,686.9 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 1,196.4 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 17,497.1 мянган төгрөгөөр, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 196.3 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 11,779.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн гэх мэт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 1,148,015.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 1,069,292.9 мянган төгрөгийг зарцуулж, тогтмол зардлын хэмнэлт 9,827.4 мянган төгрөгийг төвлөрүүлэн 68,930.3 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,069,292.9 мянган төгрөг буюу 93.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>							
	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
1	71802 Сургуулийн өмнөх боловсрол	1	802330- Хүүхэд хамгаалал	920.6	920.6	-	100.0
		2	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,294.3	1,280.0	14.3	98.9
		3	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	75,062.3	71,411.6	3,650.7	95.1
		4	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,786.3	2,786.3	-	100.0
		5	81823- Боловсролын багшийн сургалт	1,294.3	1,260.0	34.3	97.3
		6	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	4,835.0	4,800.0	35.0	99.3
		7	81834- Боловсролын стандарт сургалт	935,720.4	870,559.5	65,160.9	93.0
		8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	46,374.3	46,374.2	0.1	100.0
		9	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	79,728.0	69,900.6	9,827.4	87.7
		Нийт		1,148,015.5	1,069,292.9	78,722.6	93.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол	40,850.9	40,850.9	НТШ
	Нийт дүн	40,850.9	40,850.9	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн./ -ыг 2 удаа зарлаж, гүйцэтгэгч ирээгүй учраас урьд оны гэрээг үргэлжлүүлж “Дөлгөөн болор сан ” ХХК-тай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг компанийн захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 774,310.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,743.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд нийт 28 төрлийн 159 мэдээллийг байршуулахаас ил тод, бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит “ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 919 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн алдаа илэрч 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1		1		100.0
Нийт дүн	1		1		100.0

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 6,342.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Худалдан авсан 6,342.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа материалын зардлаар бүртгэж тусгасан,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 4,880.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 1,100.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 3,780.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. 2017 онд тус цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан Х.Өлзийсайханыг ажлаас чөлөөлөгдөхөд тооцоог бүрэн хийгээгүйгээс цалингийн урьдчилгааны 1,100.0 мянган төгрөгийг суутгаагүй, авлага үүсгэсэн боловч одоог хүртэл барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн урьдчилгааг Х.Өлзийсайханаар нөхөн төлүүлэх, төсвийг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үнэ төлбөргүй хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 3,780.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийг бараа материалын зардлаар бүртгэж тусгасан	1	6,342.7			1	6,342.7	1	6,342.7				
Нийт	1	6,342.7			1	6,342.7	1	6,342.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага барагдуулах ажил зохион байгуулаагүй	1	1,100.0			1	1,100.0						
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1	3,780.0					1	3,780.0				
Дүн	2	4,880.0			1	1,100.0	1	3,780.0				



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 54/A.1850385

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2017 онд тус цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан Х.Өлзийсайханыг ажлаас чөлөөлөгдөхөд тооцоог бүрэн хийгээгүйгээс цалингийн урьдчилгааны 1,100.0 мянган төгрөгийг суутгаагүй, авлага үүсгэсэн боловч одоог хүртэл барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.11: “Хууль тогтоомж,зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цалингийн урьдчилгааны авлагыг барагдуулж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Д.Энхмаа, нягтлан бодогч А.Сосор нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.НАРАНЧИМЭГ

432504229

АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймаг Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	СЭА-2025/120/НА-СТА-ТШЗ
-----------------	---	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	--	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар	СЭА-2025/120/НА-СТА-ТШЗ	1.6 Огноо	2025.02.24	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	1,100,000.00
--	-------------------------	-----------	------------	----------------------------	--------------

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа зөрчлийн товч утга	2017 онд тус цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан Х.Өлзийсайханыг ажлаас чөлөөлөгдөхөд тооцоог бүрэн хийгээгүйгээс цалингийн урьдчилгааны 1,100.0 мянган төгрөгийг суутгаагүй, авлага үүсгэсэн боловч одоог хүртэл			
	Алдаа зөрчлийн ангилал	Хууль, тогтоомж зөрчсөн			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг орьмдуу)	4.2.1.11: "Хууль тогтоомж,зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль		
		Заалт	20.2.5		
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаал			
	Заалт	4.2.1.9, 4.2.1.11			

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	
	Тухайн байгууллагын дансанд	

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Өр авлагын журнал		2024 он	
2				

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Б.Наранчимэг	Аудитор	Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэг	Эрхлэгч	Д.Энхмаа	99227420
				Нягтлан бодогч	А.Сосор	99628283

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	11/25	-	
2	Аудитын менежер	11/25	-	

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
---	--------------	----------	-------	------------

1	Тэргүүлэх аудитор	Ч.Энхтуяа	2/25	
2				

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Гарын үсэг	
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо	2025.02.24	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр	Шаамар сумын Дулаанхан тосгоны 3 дугаар цэцэрлэг	
		Ажилтны	Овог нэр	А.Сосор
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр	Пийк Ом Аудит ХХК	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		